



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 10

Есөнбулаг сум

**Ашигт малтмалын хайгуулын тусгай
зөвшөөрлийн тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн Тайшир сумын Бор нэртэй газар нь усны сан бүхий газарт орж байгаа тул ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгуулах боломжгүй гэж үзсүгэй.

2. Тогтоолыг холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлж, ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

ДАРГА  Т.ГАНЗОРИГ